АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.01.04 Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, 2018 дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгууллагын чиглэлээр:

1.1 Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, тайланг нэгтгэн боловсруулж, 2017 оны тайлангийн хурлыг зохион байгуулав.

Байгууллагын 2018 оны зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Хэлтэс, албадаас 2018 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулах, Төсвийн төвлөрүүлэн захирагчаас шууд захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээ, Төсвийн шууд захирагчаас хэлтэс, албадын даргатай, хэлтсийн даргаас албан хаагчидтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав.

Даргын зөвлөлийн хуралдаанаар 2018 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хуваарийн дагуу 6 удаагийн хуралдаан, 13 удаагийн шуурхай зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав.

Байгууллагын 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, тайланг нэгтгэн боловсруулж, тайлангийн хурлыг зохион байгуулав. Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийж, хэлтэс, албадад гүйцэтгэлийг ханган ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль сахиулахын Их сургууль, Монголын Хуульчдын Холбооны төлөөллүүдийг оролцуулан хамтран зохион байгуулсан “Эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа-Хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангаж, Зөвлөмж”-ийг боловсруулан эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ажлыг хариуцан зохион байгуулсан.

Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт заасныг үндэслэн “2018 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2017 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчилсэн бүртгэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хороонд, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэгт заасны үндэслэн “Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явц байдлын талаар” танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Үндэсний статистикийн газар, Авлигатай тэмцэх газрын дарга нарын хамтран батлах ХАСХОМ-1 тайлангийн маягт, маягт нөхөх зааврыг боловсруулж Үндэсний статистикийн газар даргын 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар олгосон зөвшөөрлийг баримтлан АТГ-ын даргын 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаалаар ХАСХОМ-ийн тайлангийн маягтыг шинэчлэн баталсны дагуу дээрх тайланг болон гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, гэмт хэргийн статистик мэдээг боловсруулан Үндэсний статистикийн хороонд хүргүүлж, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан “Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”-ын талаарх мэдээллийг боловсруулж хэвлүүлэн УИХ-ын Тамгын газарт хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. Мөрдөн шалгах хэлтэстэй хамтран “Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийн зорилго”-ыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг гаргах шалгуур үзүүлэлт болох “Хээл хахууль авсан бүртгэгдсэн гэмт хэрэг”, “Гэмт хэрэг үйлдсэн төрийн албан хаагч” гэсэн тоон үзүүлэлтүүдийг гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, “Авлига, албан тушаалтнуудын хууль бусаар хөрөнгөжих, мөнгө угаах болон албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” танилцуулга, саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд гэх мэтээр шаардлагатай мэдээлэл, танилцуулгыг бэлтгэж эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэв.

Эрүүгийн хууль “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд эрх бүхий албан хаагчид ажиллаж байгаа ба нэр бүхий албан хаагчид “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг”, Хуульчдын холбоо, Нээлттэй нийгэм, форумаас санаачлан зохион байгуулсан дээрх хуулиудыг хэрэглэхэд тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийн талаарх уулзалт, хэлэлцүүлэгт тус тус оролцов. Монгол Улсын ерөнхийлөгчийн ажлын албанаас зохион байгуулсан иргэд, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар авах арга хэмжээг тодорхойлох ажлын хэсэгт нэр бүхий албан хаагчид Дундговь, Өмнөговь, Өвөрхангай аймагт, Төв, Говьсүмбэр, Дорноговь аймагт томилолт оор ажиллав.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”, “Өмгөөллийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Төрийн албан хаагчийн хариуцлагын тухай хууль” “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” болон “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”, “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам”-ын төслүүдэд тусгах саналыг боловсруулан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүү, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ХЗДХЯ-аас боловсруулан батлуулах “Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд нэр бүхий албан хаагчид ажиллаж байна.

Мөн Малайз улстай байгуулах эрх зүйн харилцан туслалцааны гэрээний төсөл, Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Европын конвенцид нэгдэн орох актын төслүүдтэй танилцан холбогдох саналыг, мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын зургаа дахь удаагийн ээлжит тайланд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос өгсөн дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжийг 2018-2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-д тусгагдсан тухайн байгууллага хариуцан хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний гүйцэтгэлийг гарган ХЗДХЯаманд, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын биелэлтийн явцын /2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл/ талаарх мэдээллийг боловсруулан Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлсэн.

Эрх зүйн акт эмхлэх ажлын хэсгийн хүрээнд шаардлагатай эрхийн актуудыг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, бусад ажлын хэсгээс ирүүлсэн төслүүдийг хянах зэрэг ажиллагаануудыг хариуцан хийж, шинэчлэн боловсруулсан 18 багц журам, тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 10, 84 эрхийн актын хүчингүй болсонд тооцох тухай төслийг тус тус Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулав. Эрхийн актуудын цахим сан үүсгэж, албан хаагчид үйл ажиллагаандаа ашиглах боломжийг бүрдүүлсэн. Тамгын хэлтсийн хамтын сангийн журмын төсөл боловсруулан хэлэлцүүлж, батлуулав.

Хилийн хориг тавих тушаалыг хүчингүй болгох тухай АТГ, ХХЕГ, ТЕГ, ИХШХЕГ-ын хамтарсан тушаал, “АТГ, ЦЕГ-ын хамтран ажиллах журам”-ыг баталсан тушаал, Үндэсний статистикийн хорооны зөвшөөрөлтэйгөөр баталсан “Маягт, заавар батлах тухай” тушаалыг хүчингүй болгох төслийг боловсруулж баталгаажуулсан. Мөн “Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг боловсруулж, ТЕГ-ын саналыг авч, гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол, гэмт хэргийн мэдээ, ХАСХОМ-ийн тайлангийн маягтыг холбогдох хэлтэстэй хамтран боловсруулж, Үндэсний Статистикийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшөөрүүлж байгууллагын даргын тушаалаар тус тус албажуулав.

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Засгийн газрын 28 дугаар хуралдаанаас “Захиргааны хэм хэмжээний актын талаар авах зарим арга хэмжээний тухай” танилцуулгыг хэлэлцээд гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам”, “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам” /шинэчилсэн найруулга/-ыг ХЗДХЯаманд хүргүүлж, улсын бүртгэлд бүртгүүлэв. Ийнхүү нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр дээрх журмуудыг нийтийн албаны удирдлагыг хэрэгжүүлэх байгууллагууд нэг мөр мөрдөхөөр болов. “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”-ыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.

Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан “Хууль дээдлэх ёс ба авлига, ашиг сонирхлын зөрчил”, “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан: Асуудал ба шийдэл” сэдвээр иргэний нийгмийн төлөөлөл, хуульч, судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлэг, Азийн сантай хамтран “Авлигын нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ, үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажил” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулав.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээний 4 дэх удаагийн мониторингийн ажлын бэлтгэл ажлыг хангаж, шинжээчдийн багийн гишүүдээс АТГ-ын болон төрийн бусад 36 салбар, байгууллагуудын төлөөлөлтэй уулзах, харилцан мэдээлэл солилцох, нэгдсэн болон салбар хуралдааныг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэн шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллав.

Азербайджан Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлигын эсрэг хороотой хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Онц залилангийн гэмт хэрэгтэй тэмцэх албатай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус байгуулав.

Байгууллагын хэмжээнд 2018 онд иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор 371 гэрээ, 3 санамж бичиг /Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ, Нийслэлийн Тээврийн газар, “Улаанбаатар смарт карт” ХХК, “Глоб интернешнл төв” ТББ/ байгуулагдсан байна.

Нийтийн албан тушаалд нэр дэвшигч нь тухайн ажлын байранд тавигдах шаардлага хангахгүй байгаа болон ашиг сонирхлын зөрчилтэй гэх шийдвэр гаргасантай холбогдуулан Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасан нэр бүхий 6 иргэний маргааныг хянан шийдвэрлэх анхан, давж заалдах шатны шүүх хуралдаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, мөн эрүүгийн хэрэгт хохирогчоор оролцож байгаа ба байгууллагын нэр хүндэд хууль бусаар халдсан гэх зөрчлийн хэрэгт байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон хуулиар олгосон эрхийн хүрээнд ажиллав. Мөн нийтийн албан тушаалтанд хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн нэр бүхий 4 иргэнд холбогдох зөрчлийн 2 хэрэгт хариуцагчаар, байгууллагын ажил хэргийн нэр хүндэд халдсан гэх 1 зөрчлийн хэрэгт хохирогчийг төлөөлөн оролцсон. Мөн нийтийн албан тушаалтан хууль бусаар хөрөнгөжсөн асуудалд нийтийн ашиг сонирхлыг хамгаалуулах, зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр УЕПГ-т хандсан. Шүүх хуралдаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тус бүрт хариу тайлбар, давж заалдах, хяналтын шатны шүүхэд гомдол, тайлбар гаргах, холбогдох баримт хүргүүлэх болон холбогдох бусад ажиллагаануудыг хийв.

Байгууллагын удирдлагаас албан хаагчдын ар гэрийнхнийг хүлээн авч уулзан санал,

хүсэлтийг сонсох арга хэмжээг анх удаа, байгууллагаас чөлөөнд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг тус тус зохион байгуулав.

Бичиг хэргийн ажилтан ажлын байрны тодорхойлолтод заасан үндсэн үүргийн дагуу А тушаал 93, Б тушаал 53, 3206 албан бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн заавар”, зохих стандартын дагуу бэлтгэн гаргасан байна. Байгууллагын бичиг хэргийн ажилтанд хариу шаардаагүй албан бичиг 5818 хариу шаардсан 5897 албан бичиг хүлээн авч,11261 албан бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргэсэн байна. Нийт 22974 албан бичгийг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.

2017 онд бусад байгууллагад албан тушаалтанд хүргүүлсэн албан бичгийг архивын шаардлагад нийцүүлэн цэгцэлж 41 архивын нэгж үүсгэж, байгууллагын архивд шилжүүлсэн ба 2018 оны албан бичгийг 27 архивын нэгж үүсгээд архивд шилжүүлэхэд бэлэн болгоод байна.

Хөдөө орон нутгийн шууданд болон албан байгууллагад 14573 бичиг хүргэсэн байна.

1.2 Гадаад харилцааны чиглэлээр-Гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагууд хоорондын Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх чиглэлээр Канад Улсын Хатан хааны Морьт Цагдаагийн газар, БНХАУ-ын Үндэсний Хяналтын хороо, Индонез Улсын Авлигатай тэмцэх газруудтай холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлэхээр, АНУ-ын Хууль зүйн департамент, Холбооны мөрдөх товчоо, Их Британийн Авлигын эсрэг олон улсын мэдээллийн төвтэй холбоо тогтоож, мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

Дэлхийн банкны Хулгайлагдсан хөрөнгө буцаах СтАР санаачилгатай хамтран ажиллах хөтөлбөр боловсруулахад тусгах саналыг боловсруулан уламжилснаар 2019 оноос 2 жилийн хугацаанд АТГ-тай хамтран ажиллах 10 модульт төлөвлөгөөг ирүүлснийг хүлээн авч, хамтран хэрэгжүүлэхээр санал солилцоод байна.

Азийн хөгжлийн банктай хамтран 2018 оны 12 дугаар сараас 2020 оны 12 дугаар сарын хооронд “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд зориулан Монгол улсын засгийн газарт олгох техникийн туслалцаа”-ны төслийг хэрэгжүүлэхээр батлуулав. Төсөл 3 үе шаттай хэрэгжих бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд холбогдох уулзалтуудыг хийх, харилцан мэдээлэл солилцох, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий Прокурорын газарт мэдээлэл хүргүүлэх, авах зэрэг ажлыг хариуцан ажиллалаа.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний Истанбулын үйл ажиллагааны төлөвлөгөөний Монгол Улсын 4 дэх удаагийн үнэлгээ хийх үнэлгээний баг 12 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд Монгол Улсад ажилласантай холбогдуулан баримт материалыг бэлтгэх болон холбогдох бусад ажилд дэмжлэг үзүүлж ажилласан.

АТГ-ын удирдлагын Азийн хөгжлийн банкны төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, Турк Улсаас Монгол Улсад суух Элчин сайд Мухиттин Яазал, АНУ-ын Холбооны мөрдөх товчооны төлөөлөгч Роберт Стюарт, Хулгайлагдсан хөрөнгө буцаах /Стар/ санаачлагын шинжээч Шервин Мажлесси, Дмитри Котляр, Азийн Сангийн Суурин төлөөлөгч Марк Коэнин, Азийн хөгжлийн банкны Хуулийн хэлтсийн дарга Саид Зайданяш, Эдийн засагч Деклан Магий, Олон Улсын нээлттэй засгийн түншлэлийн Иргэний нийгмийн асуудал хариуцсан захирал Паул Массен, Ази, номхон далайн бүс нутаг хариуцсан зохицуулагч Шреяа Басу, Хуулийн шинэчлэлд засгийн газруудыг уриалж, хүмүүсийг идэвхжүүлэх түүнчлэн энх тайван, шударга ёс, тогтвортой хөгжил, эдийн засгийн боломжийг сурталчлах үйлсэд байгууллагуудыг бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Итали улсын Ром хотод төвтэй Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага /IDLO/ -ийн Зүүн Европ, Төв Азийн Хөтөлбөрийн зохицуулагч Анастасия, Хулгайлагдсан хөрөнгө буцаах /СтаР/ санаачлагын шинжээч Найжел Бартлетт, Жон Бентон, ИБУИНВУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Филип Малоне, АНУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яамны ажилтан Жеффри Жоз, Европын сэргээн босголт хөгжлийн банкны төлөөлөгчидтэй хийсэн уулзалт Австралийн холбооны цагдаа, Дотоод хэргийн яам, Индонез Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Хөрөнгө буцаах төвийн төлөөлөгчид, Европын Аюулгүй

байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчиллын институц, хүний эрхийн албаны төлөөлөгч нартай хийх уулзалтын бэлтгэл ажлыг ханган ажиллав.

Индонези улсын Бали хотноо зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний Удирдах зөвлөлийн уулзалт, Бүгд хуралд байгууллагын төлөөлөгчид оролцсон. Тус хурлуудын үеэр Монгол Улс удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, сүлжээний 2019 онд манай байгууллага тус сүлжээний Бүгд хурал болон Удирдах зөвлөлийг Улаанбаатар хотноо зохион байгуулах эрхийг авч, олон улсын арга хэмжээнүүдэд тус сүлжээний даргалагч улсын хувиар оролцох эрхтэй болсон.

Гүйцэтгэх ажлын хэлтсийн дарга А.Дөлгөөн тэргүүтэй төлөөлөгчид Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо зохион байгуулагдсан Олон Улсын үзэсгэлэн, хуралд, ГАХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал Индонез Улсын Джокьякарта хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн Хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээний жилийн ээлжит уулзалт, Тайландын Вант Улсын Бангкок хотод 2018 оны 07 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Хууль сахиулах олон улсын академийн “Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах аргачлал” сэдэвт сургалтад, Судалгаа шинжилгээний албаны ажилтан Д.Жаргалан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний Авлигын эсрэг Истанбулын төлөвлөгөөний хүрээнд Киргизстан Улсын хэрэгжилтийн тайланг хянах багт, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн Словени Улсын Любляна хотод зохион байгуулагдсан тус улсын Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийн хэрэгжилтийн тайланг хянах олон улсын шинжээчдийн багт, байгууллагын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал, гадаад харилцааны ажилтан, комиссар Х.Билгүүн, Ж.Болорчимэг нар Америкийн Нэгдсэн Улсын Нью Йорк хотод зохион байгуулагдсан Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын хэрэгжилтийг дэмжих, шинээр гарч буй чиг хандлагыг тодорхойлох өндөр түвшний уулзалтад төлөөлөгчөөр, Судалгаа, шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Ц.Шинэбаяр Австри Улсын Вена хотноо зохион байгуулагдсан АЭНҮБК-ийн гишүүн орнуудын Бага хурлын Хөрөнгө буцаан авах асуудлаарх Ажлын хэсгийн хуралдаан, АЭНҮБК-ийн Хэрэгжилтийг хянах механизмийн хоёр дахь мөчлөгт оролцох үндэсний зохицуулагч болон Засгийн газрын шинжээчдэд зориулсан сургалтад, Гүйцэтгэх ажлын хэлтсийн Нэгдүгээр тасгийн дарга, ахлах комиссар П.Лхагвасүрэн Непал Улсын Катманду хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүс нутгийн Мөнгө угаахтай тэмцэх бүлгийн ээлжит хуралд, байгууллагын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал, Гүйцэтгэх ажлын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал, Гадаад харилцааны ажилтан, комиссар Х.Билгүүн нар БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конг мужид нар томилолтоор ажиллах, Дэд дарга, эрхэлсэн комиссар Ц.Нямдорж, Гүйцэтгэх ажлын хэлтсийн Хоёрдугаар тасгийн ажилтан, комиссар Б.Энхбаатар нар Чех Улсын Прага хотод зохион байгуулагдсан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Эдийн засаг, байгаль орчны газрын хуралд, Гүйцэтгэх ажлын хэлтсийн ажилтан, комиссар Х.Ихмөрөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний Хууль сахиулах санаачилгын уулзалтад, УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү Дани Улсын Копенхаген хотод зохион байгуулагдсан Авлигын эсрэг олон улсын хуралд, Казахстан Улсын Астана хотод зохион байгуулагдсан Азийн хөгжлийн банк болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хамтарсан Ази, Номхон далай бүс нутгийн Авлигын эсрэг санаачилгын удирдах зөвлөлийн уулзалтад УССГХ-ийн ажилтан, комиссар Ч.Батчулуун, Ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн, ХШДШХ-ийн ажилтан, комиссар Х.Анхбаяр нар Австри Улсын Вена хотноо 11 дүгээр сарын 5-6-ны өдрүүдэд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулсан “Орон нутгийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх шинэ аргачлал” сэдэвт семинарт, УССГХ-ийн ахлах ажилтан, ахлах комиссар Д.Цэнд-Аюуш БНХАУ-д зохион байгуулагдсан “Зүүн хойд Азийн бүсийн гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин” сэдэвт семинарт, ХШДШХ-ийн ажилтан, комиссар Б.Гэрэлмаа БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооноос 5 дугаар сард зохион байгуулсан Авлигатай тэмцэх салбарт ажилладаг мэргэжилтнүүдэд зориулсан сургалтад, Авлигын эсрэг олон улсын академиас БНХАУ-д зохион байгуулсан “Зүүн болон Зүүн өмнөд Азийн

бүсийн Авлигын эсрэг зуны сургалт”-д нэр бүхий албан хаагчдыг оролцуулах оролцуулах бэлтгэл ажил хангаж, дэмжлэг үзүүлэн ажилласан.

Байгууллагын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал тэргүүтэй төлөөлөгчид Азербайжан Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлигын эсрэг хорооны урилгаар, ЕвроЖаст буюу Европын шүүх, хууль сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагааны байгууллагын урилгаар Нидерландын Вант Улсад, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад, АНУ-ын Төрийн департаментын урилгаар байгууллагын эрх бүхий албан тушаалтны төлөөлөл томилолтоор ажиллах бэлтгэл ажлыг хангав. Мөн Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын урилгаар тус улсад туршлага судлах айлчлалыг АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан бөгөөд байгууллагын удирдлага, эрх бүхий бусад албан тушаалтнууд хамрагдав.

“Хулгайлагдсан хөрөнгийг буцаах Бүгд найрамдах Киргиз Улс “Стамбулын Авлигын эсрэг төлөвлөгөө”-г хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ өгөх олон улсын шинжээчдийн багт тус байгууллагын ажилтан ажилласантай холбогдуулан Киргиз Улсын нөхцөл байдлын талаарх тайланг бэлтгэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагад хүргүүлэв.

Дэлхийн банкны Хулгайлагдсан хөрөнгө буцаах СтАР санаачилгатай хамтран 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрүүдэд хууль сахиулах байгууллагуудын дундах “Хууль сахиулах ажилтнуудын хэлэлцүүлэг”, 10 дугаар сард “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны анхан шатны сургалт”, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2018 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд “Оффшор бүс нутгийг ашиглан мөнгө угаах, түүнтэй тэмцэх олон улсын туршлага” сэдэвт сургалт зохион байгуулж, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг оролцуулав.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга (StAR)”-тай хамтран ажиллах урт хугацааны төлөвлөгөөнд тусгуулах саналыг боловсруулж, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс жил болгон гишүүн орнуудаас цуглуулдаг Авлигын эсрэг үйл ажиллагааны явцын тайлан болон орон нутаг дахь авлигын асуудлаар мэдээлэл бэлтгэн хүргүүлсэн.

<u>1.3 Байгууллагын хэмжээнд хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэл</u> 2017 онд иргэд байгууллагаас 1324 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 658 гомдол мэдээлэл хүлээн авч хуулийн дагуу шалгаж шийдвэрлэсэн бол 2018 онд иргэд байгууллагаас 1887 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 858 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал өргөдөл, гомдол, мэдээлэл 563 нэгжээр буюу 42.5 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 200 нэгжээр буюу 23.3 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна. /2018.01.01-12.31/

Нийт гомдол мэдээллээс Мөрдөн шалгах хэлтэс 858 буюу 45.5 хувь, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс 341 буюу 31.6 хувь, Гүйцэтгэх ажлын хэлтэс 88 буюу 8.1 хувь,

Тамгын хэлтэс 6 буюу 0.7 хувь /АБХШНА 5, бусад 1/, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс 4 буюу 0.3 хувь, “харьяаллын бус” 94 гомдол, мэдээлэл байна.

Тайлант хугацаанд авлига, албан тушаалын талаарх мэдээлэл хүлэн авах 18001969 дугаарын утсаар ирсэн 244 гомдол, мэдээллийг хүлээн авч, цахим бүртгэлд бүртгэснээс 219 гомдол, мэдээллийг шийдвэрлүүлэхээр холбогдох нэгжид хүргүүлж, 25 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлсэн байна.

Хоёр: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг
зохион байгуулах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2017 оны тайланг нэгтгэн боловсруулах ажлын хүрээнд хөтөлбөрт заасны дагуу тайлан ирүүлэх 78 байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллалаа.

Хөтөлбөрт 2017 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 144 ажил, арга хэмжээний гүйцэтгэлийн тайланг гаргаж, хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн бөгөөд хэрэгжилт 32.9

хувьтай байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 2017 онд гүйцэтгэвэл зохих 216 арга хэмжээний 205 буюу 94.9 хувь нь хөтөлбөрийн эхний үе шат буюу 2017-2019 онд, үүнээс 144 буюу 66.7 хувь нь 2017 онд хэрэгжиж эхлэхээр, нийт төсвийн 57,3 хувийг хөтөлбөрийн эхний үе шатанд зарцуулахаар төлөвлөсөн байх ба 2017 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс нийт 499.6 сая төгрөгийг санхүүжилт хийгдсэн дүнтэй байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2018 оны явц байдлын тайланг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас хүлээн авч нэгтгэв. АТҮХ-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлын танилцуулгыг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын АТҮХ-ийн хэрэгжилтийн 2017 оны тайлан, 2018 оны төлөвлөгөөний биелэлтийн явц байдлын тайлан, АТГ-ын багуудын 2017, 2018 онд яам, агентлаг, төрийн өмчит байгууллагуудад ажилласан тайлан, холбогдох бусад мэдээллийн хүрээнд нэгтгэн боловсруулав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санд тусгах шаардлагатай мэдээлэл, ажлын даалгавар, мэдээллийн сангийн агуулгад оруулах нэмэлт мэдээллийг боловсруулж, эрх бүхий байгууллагын удирдлагатай уулзалт зохион байгуулж, мэдээллийн сангийн ажиллах зарчим, агуулгын талаар харилцан мэдээлэл солилцож байна.

2.1 Үндэсний хөтөлбөрийг тайлбарлан таниулах, сурталчлах чиглэлээр-ажлыг тасралтгүй зохион байгуулав. Тухайлбал, “Транспэрэнси Интенэшнл Монгол” ТББ-аас 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдсан “Авлигын эсрэг хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” болон “Авлигын эсрэг залуучуудын оролцоог дэмжих нь” сэдэвт уулзалт, 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Улс төрийн санхүүжилт ба өндөр түвшний авлигаас сэргийлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг, “Глоб интернешнл төв” ТББ-аас 2018 оны 04 дүгээр сарын 13,14-ний өдрүүдэд зохион байгуулсан “GSP+ механизмаар дамжуулан хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийн гарааны семинар, Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан 2018 оны 05 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулсан “Эрх мэдлийг хяналтандаа байлгах нь: Хэвлэл мэдээлэл, шударга ёс, хууль дээдлэх ёс” сэдэвт хэлэлцүүлэг, Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Захиргааны байгууллагын шийдвэрийн улмаас учирсан хохирол, түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг, ЗГХЭГ-аас 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Нээлттэй засгийн түншлэл”-ийн зөвлөлдөх уулзалт, 2018 оны 06 дугаар сарын 29-ны өдөр “Нээлттэй засгийн түншлэлийн 2018-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө”-ний үндсэн чиглэлийг тодорхойлох ажлын хэсгийн уулзалт зэрэгт тус тус оролцож Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл хийв.

2.2 Авлигын эсрэг сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэх, нийтийн албан тушаалтнуудад зориулсан сургалтын чиглэлээр-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10-т “Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд авлигын эсрэг цогц сургалтыг удирдах албан тушаалтнууд /захиргаа удирдлагын нэгжийн дарга нар, дотоод хяналт, аудитын нэгжийн дарга нар, бусад удирдах албан тушаалтан/, Хүний нөөц, хууль, эрх зүй, худалдан авах ажиллагаа, санхүү, төсөв хариуцсан ажилтан, нийтийн албанд шинээр томилогдсон ажилтнуудад зэрэг нийт 9 зорилтот бүлэгт хуваан зохион байгуулахаар сургалтын хөтөлбөр, хуваарийг боловсруулав.

Уг хөтөлбөр, хуваарийн дагуу “Авлига, түүний шалтгаан, хор хөнөөл”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал”, “Нийтийн албан тушаалтны ХАСУМ, ХАСХОМ-ийн зөрчил, анхаарах асуудал”, “Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны дахь нийтлэг алдаа”, “Худалдан авах ажиллагаан дахь нийтлэг алдаа”, “Ашиг сонирхлын зөрчил”, “Авлигын гэмт хэрэг-шинэ зохицуулалт”, “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” зэрэг нийт 9 сэдвийн хүрээнд цогц сургалтыг Удирдлагын академи”, МУИС, Отгонтэнгэр их сургууль, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа.

Тайлант хугацаанд сургалтад нийт 8497 нийтийн албан тушаалтан хамрагдсаны 1351 нь буюу 15.9 хувь нь төрийн удирдах албан тушаалтан, 7146 нь буюу 84.1 хувь нь гүйцэтгэх албан тушаалтан байлаа. Тус төвд сургалтад Захиргаа, удирдлагын нэгжийн дарга 458,

Дотоод хяналт, аудитын нэгжийн дарга 170, бусад нэгжийн дарга нар 425, үйлчилгээний удирдах албан тушаалтан 255, хүний нөөцийн ажилтан 255, хуулийн асуудал хариуцсан ажилтан 170, худалдан авалт хариуцсан ажилтан 425, санхүү төсөв хариуцсан ажилтан 425, нийтийн албанд анх томилогдсон 595, бусад нийтийн албан тушаалтан 5319, нийт 8497 нийтийн албан тушаалтан хамрагдсан болно.

Олон нийтийн төвд зохион байгуулж байгаа сургалтын үйл ажиллагааг цахимжуулах, бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сантай болох зорилгоор программ хангамжийн ажлын даалгавар боловсруулж, программын төслийг боловсруулах шатандаа явж байна.

Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А3 сертификат олгох сургалт 14 удаа зохион байгуулсан бөгөөд уг сургалтад 71 байгууллагын 650 гаруй албан хаагч хамрагдсан байна. Мөн Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сертификатын эрх олгох сургалтыг “Худалдан авах үйл ажиллагааны хөтөч” ТББ, “Худалдан авах ажиллагааны боловсролын төв” ТББ-уудтай хамтран зохион байгуулсан бөгөөд уг сургалтад яам, агентлаг, нийслэл, дүүргийн иргэний хяналтын зөвлөлийн 80 гишүүнийг хамруулсан.

“Авлигын эсрэг сургалтын модуль, гарын авлага боловсруулах, сургалтын хэрэгцээ, шаардлагыг судлан тогтоох, сургагч багш бэлтгэх” чиглэлээр Удирдлагын академитай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу тус академийн дэд захирал Д.Цэдэв, Сургалтын албаны дарга Я.Бямбабаяр, Мэргэжил дээшлүүлэх институтийн захирал Д.Мягмарсүрэн, Нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч Ч.Эрдэнэчимэг болон модуль боловсруулах ажлын хэсгийн гишүүдтэй удаа дараа уулзалт, ярилцлага зохион байгуулж, санал солилцсон ба АТГ-ын захиалсан 6 сэдэвт сургалтын модулийг Удирдлагын академиас хүлээн авч, сургалтын модулийн дагуу сургагч багш бэлтгэх туршилт сургалтыг 12 дугаар сард зохион байгуулав.

Төрийн албан хаагчдад зориулсан заавал хамрагдах шаардлагатай ёс зүйн болон сонирхлын зөрчлийг зохицуулах сургалтын хөтөлбөр, модуль боловсруулах, сургагч багш бэлтгэх чиглэлээр НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслөөс 50.000 америк долларын санхүүжилтийг шийдвэрлүүлэв. НҮБХХ-ийн “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр дараах ажлыг хийж гүйцэтгэв.

-Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын модуль, гарын авлага боловсруулах, сургагч багш бэлтгэх ажлыг хийж гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт зарлаж, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуулийн зөвлөх багтай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн болно.

-Зөвлөх багийн гишүүдтэй хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй”, /6 сургалтын модуль/ “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” /8 сургалтын модуль/ боловсруулсан бөгөөд энэ сэдвээр гарын авлагыг боловсруулаад байна. Төрийн албан хаагчийн ёс зүй, Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь сургалтын модулиар сургагч багш бэлтгэх туршилт сургалтыг 2018.12.15-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад 21 аймгаас тус бүр 3 төрийн албан хаагч /63 хүн/, нийслэлээс Иргэний хяналтын зөвлөлийн 69 гишүүн, нийт 132 хүнийг хамруулав. Сургагч багшийн сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг баталгаажуулах сургалтыг нийслэл, дүүрэг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийтийн албан тушаалтанд зориулан сургагч багш нартай хамтран цуврал байдлаар зохион байгуулж ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгож, чадавхжууллаа.

-Ёс зүйн сургалтын модулийг сайжруулах зорилгоор “Төрийн албаны ёс зүй ба удирдлага” номын орчуулгыг НҮБХХ захиалан гүйцэтгүүлснийг хүлээн авч, орчуулгыг хянан тохиолдуулах, дахин нягтлах ажлыг Авлигатай тэмцэх газар хариуцан гүйцэтгэж байна.

2.3 Иргэний хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах чиглэлээр- Төрийн байгууллага, албан тушаалтны аливаа шийдвэр гаргах ажиллагааны ил тод

байдлыг хангах, албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдалд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэгт иргэд, олон нийтийн хяналт тавих, мэдээлэл авах эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр авлигаас урьдчилан сэргийлэх *Иргэний хяналтын* зөвлөлийн 152 гишүүнийг 21 аймаг, яам агентлаг, нийслэл, дүүргийн хэмжээнд гэрээний дагуу ажиллуулав.

Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн гэрээг шинэчлэн боловсруулсан ба урамшуулал олгохтой холбогдуулан багуудаас урамшуулал олгох гишүүдийн ажил дүгнэсэн хуудас, гэрээг хүлээн авч нэгтгэх, яам, агентлаг, нийслэл, дүүргийн иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаатай танилцах, зөвлөмж, чиглэл өгөх уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэв.

Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сертификатын эрх олгох сургалтыг 2018 оны 01 дүгээр сарын 22-24-ны өдрүүдэд, мөн тэднийг сургагч багшаар бэлтгэх зорилгоор “Төрийн албаны ёс зүй”, “Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь” сэдэвт сургалт, Удирдлагын академийн 2 модулийг турших сургалтад тус тус хамруулав. Мөн Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийг Эрүүл мэндийн салбарт буюу аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгооны төв, төрөх, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хорооны 5 өрхийн эмнэлэгт 2018 оны 2 дугаар сарын 5-ны өдрөөс 45 хоногийн хугацаанд ажиллуулах шаардлагаар “Эрүүл мэндийн салбар дахь төрийн үйлчилгээ, анхаарах асуудлууд”, “Эрүүл мэндийн салбар дахь авлигын нөхцөл байдал”, “Эрүүл мэндийн салбарт ажиллах чиглэл” гэсэн үндсэн 3 сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулж, онлайн хэлбэрээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн наймдугаар зорилт (иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх)-ын хүрээнд засаглал, ил тод байдал, хараат бус хэвлэл мэдээллийг хөхиүлэн дэмжих, хэвлэлийн эрх чөлөөний мониторинг, сэтгүүлчдийг чадавхжуулах чиглэлээр 1999 оноос өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулж буй “Глоб интернешнл төв” ТББ байгууллагатай 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдөр “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав. Мөн сэтгүүлчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд цахим мэдээллийн сайтын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийн төсөл, төсвийн төсөл, хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулаад байна.

2.4 Худалдан авах ажиллагааны үр ашигтай, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр-2018 оны 01 дүгээр сард худалдан авах үйл ажиллагааг бодлогын түвшинд сайжруулах чиглэлээр санал боловсруулж Сангийн сайдтай уулзалт хийж, “Худалдан авах ажиллагаан дахь хяналт, хариуцлага, хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгийг Сангийн яам, ТӨБЗГ-тай хамтран зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Авлигатай тэмцэх газар, УИХ-ын харьяа байгууллагууд, ЗГХЭГ, Сангийн яам, ТӨБЗГ, ШЕЗ, ШШГЕГ, бусад яам, агентлаг, Барилгын хөгжлийн төв, нийслэл, дүүрэг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 92 байгууллагын худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжийн удирдлага, мэргэжилтэн нийт 111 албан тушаалтан оролцов.

Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх эрх бүхий А-2 гэрчилгээтэй сургагч багш нар бүхий “Худалдан авах үйл ажиллагааны хөтөч” ТББ, МУИС-Бизнесийн сургууль, “Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв “ ТББ, “Хүний хөгжил судалгаа сургалтын төв” ТББ, “Худалдан авах ажиллагааны боловсролын төв” ТББ, “Төсвийн удирдлагын хүрээлэн” ТББ, “Худалдан авах ажиллагааны хөгжлийн төв” ТББ-тай хамтран “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А3 сертификат олгох” 3 өдрийн сургалтыг 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 5 дугаар сарын 11-ны өдрийг хүртэлх хугацаанд 14 удаа, 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 23-ныг хүртэл хугацаанд 5 удаа, нийт 19 удаа зохион байгуулав. Тайлангийн хугацаанд Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх эрх бүхий 6 ТББ-тай хамтран “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн

ажилтан бэлтгэх А3 сертификат олгох” сургалтад давхардсан тоогоор 102 байгууллагын 973 албан тушаалтан, АТГ-ын иргэний хяналтын зөвлөлийн 60 гишүүнийг тус тус хамруулав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн наймдугаар зорилт (иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх)-ын хүрээнд “Глоб интернешнл төв” ТББ байгууллагатай 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдөр “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулан ажиллаж байна. Уг санамж бичгийн хүрээнд “Авлигатай тэмцэхэд сэтгүүлчдийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтад хэвлэл, мэдээллийн байгууллагын 25 ажилтан хамрагдсан. Мөн “Цахим сэтгүүл зүй ба мэргэжлийн ёс зүй” сэдвээр хэвлэл мэдээллийн байгууллагын 30 ажилтанд 2 өдрийн сургалтыг Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран зохион байгуулав.

2.5 Багуудын ажлыг нэгтгэн зохион байгуулах, арга зүйн зөвлөгөөгөөр хангах хүрээнд: Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын дарга болон зарим төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтнуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх багуудаас хариуцсан салбар, байгууллагадаа ажиллах шалгалтын ажлын удирдамжийг гардуулах арга хэмжээг 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулав. Уг арга хэмжээнд Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Х.Энхжаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Ерөнхий аудитор Д.Хүрэлбаатар, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо нар оролцов. Удирдамжийн дагуу АТГ-ын ажлын багууд хариуцсан яам, агентлаг, нийслэл, дүүрэг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд ажиллан, зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, төсөв, санхүүгийн ил тод байдал, албан хаагчдын ёс зүй, хүний нөөцийн бодлого зэрэг үйл ажиллагаатай танилцан шалган туслах ажлыг гүйцэтгэв. Багуудын яам, агентлаг, нийслэл, дүүрэг, төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд, харьяа бусад байгууллагад 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс хойш ажилласан явцын тайланг танилцуулах хуваарийг боловсруулж, багийн явцын тайлантай танилцах, зөвлөмж, чиглэлийг баг тус бүр өглөө.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн жагсаалтыг үндэслэн багийн хариуцан ажилладаг салбар, чиглэл, нутаг дэвсгэрийн байдал зэргийг харгалзан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх багуудын хариуцан ажиллах төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт”, багуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор тэдгээрийн хариуцан ажиллах байгууллага, багт ажиллах албан хаагчдын хуваарийг шинэчлэн батлуулав.

Багууд шинэчилсэн хуваарь, шинэлэг удирдамжийн дагуу Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилт, явц байдалтай танилцах, шалган туслах, аймгийн Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах, иргэдээс гомдол мэдээлэл, хүлээн авах, шалгах арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор АТГ-ын 7 багийн бүрэлдэхүүн 10-11 сард 21 аймаг, 50 суманд ажиллаж ажиллан байгууллагуудын 2017, 2018 онд зохион байгуулсан үйл ажиллагаа, ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журам, заавар зэрэгтэй танилцан, зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр зөвлөмж боловсруулан аймгуудын удирдлагуудад хүргүүлэхэд бэлэн болгоод байна.

Гурав: Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар:

3.1 Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахууныг төлөвшүүлэх хүрээнд-Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигын эсрэг боловсролын түвшинг дээшлүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулав. Тухайлбал, Ерөнхий боловсролын сургуулиуд буюу Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын төвийн сургуулиуд, нийслэлийн Баянгол дүүргийн 28, Сэтгэмж цогцолбор сургууль, Баянзүрх дүүргийн 48, 92-р сургууль, Чингэлтэй дүүргийн 39, Хан-уул дүүргийн 118, Сонгинохайрхан дүүргийн ирээдүй цогцолбор, Сүхбаатар дүүргийн

4, Налайх дүүргийн Голомт, Багануур дүүргийн Боловсрол, Багахангай дүүргийн Хангай цогцолбор сургууль дээр клубийн үйл ажиллагааг эхлүүлсэн сургуулиудад “Шударга ёсны төлөө” клуб байгуулан ажиллалаа.

“Сурагч-Гэр бүл-Сургууль” сэдэвт аян зохион байгуулах хүрээнд сургуулийн орчин, гэр бүлээр дамжуулан шударга ёсны үзэл төлөвшүүлэх зорилгоор “Монголын сурагчдын холбоо” ТББ, “Монголын эцэг эхчүүдийн холбоо” ТББ, орон нутгийн Боловсролын хэлтэстэй хамтран Хөвсгөл, Орхон, Дорнод, Өмнөговь аймгийн хувийн хэвшлийн болон төрийн өмчийн ЕБС-иудад сурагчдад зориулан “Хүн байхын учир”, эцэг эхчүүдэд зориулан “Сайн аав, ээж” сэдэвт сургалт, ахлах ангийн сурагчид хамруулсан “Хүүхдийн шударга байдлын судалгаа” (2016)”-г ахлах ангийн сурагчдад танилцуулж, шударга байдлын талаар эцэг эх, багш, сурагчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Өсвөр үе, сурагчдын дунд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 10 дугаар зорилт болох “Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх” зорилтыг хангах чиглэлээр Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, Монголын Сурагчдын холбоотой хамтран Ерөнхий боловсролыг сургуулийн 8-10 дугаар ангийн сурагчдын дунд “Өөр ирээдүй” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, өдөрлөгийг 12 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгуулах чиглэлээр нийгмийн ухааны чиглэлийн хичээлүүдэд авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг тусгахаар хөтөлбөр шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт АТГ, БСШУЯ-ны төлөөлөл хамтран ажиллахаар болов. “Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг”-тэй хамтран шударга ёсны хичээл заасан 33 сургуулийн 110 багш, удирдлага, эцэг эхийн төлөөллийг оролцуулсан туршлага, солилцох уулзалтыг Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулж, мэдээлэл хийв. Мөн тус ТББ-аас эрхлэн гаргадаг “Нээлттэй сургууль” сонины дугаарт дээрх 110 багш нарын сайн туршлага, шударга ёсонд суралцах нь хичээлийг зааснаар сургуулийн орчинд гарсан өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн танилцуулга, хөтөлбөрийн 10 дугаар зорилтын талаар мэдээллийг багтаасан дугаар (2018 оны 11 дүгээр)-ыг хамтран нийтлүүлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан “... авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах” зорилтын хүрээнд их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, стандартад ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгадаг эсэх талаар судалгаа, дүн шинжилгээ хийсэн.

Азийн сан, Хууль сахиулахын их сургуультай хамтран ёс зүйн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх асуудлаар санал солилцох уулзалтад оролцож, сургалтын хөтөлбөр агуулгыг шинэчлэх, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр мэдээлэл өгч, арга зүйн удирдлагаар ханган ажилласан. Сургалтын хөтөлбөрийн төсөлтэй танилцаж санал өгч, туршилт сургалтыг 2018 оны 11 дүгээр сард хийсэн ба тус хөтөлбөр батлагдсанаар ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн сонсогчдод ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хичээлийн хөтөлбөрийн дагуу заавал хамрагдах боломж бүрдэх болно.

Монгол Улсад залуусын оролцоо, манлайлал, ёс зүйн чиглэлээр манлайллын хөтөлбөр, сургалт, нөлөөллийн арга хэмжээ идэвхтэй зохион байгуулдаг Зориг сан, “World learning” ТББ-уудтай хамтран ажиллав. Тухайлбал, “World learning” ТББ-ын Монгол дахь төлөөлөгчдийн газраас хэрэгжүүлсэн “Lead Mongolia” хөтөлбөрийн манлайлагч залуусын “Эрүүл мэндийн салбарын ил тод байдлыг дэмжих“ болон “Залуусын шударга байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ажиллах” багийн гишүүдтэй хамтран ажиллаж оюутан болон хүүхэд залуусын дунд авлигаас ангид байх, шударга ёс түгээн дэлгэрүүлэх “Гэрэл тусгая” богино хэмжээний видео бүтээх уралдааныг зохион байгуулах, дүгнэх нэг болон хоёрдугаар шатны шалгаруулалтад оролцож, цааш нь түгээх санал санаачилгыг дэмжин ажиллав. “Зориг сан”-аас оюутан залуусыг хамруулан хэрэгжүүлж буй манлайллын хөтөлбөрт авлигын эсрэг сэдвийг тусгаж, хамтран ажилласан ба энэ хүрээнд “Ардчиллын элч” залуусын манлайллын

хөтөлбөрт хамрагдагсдад авлигын ойлголт, шалтгаан, хор уршиг сэдвээр сургалт хийж чадавхжуулахад нь дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

3.2 Авлигын эсрэг сурталчилгаа хийж, түгээх ажлын хүрээнд: Нийслэлийн ИТХ, ГХУСАХЗЗ, ЗДТГ-тай хамтран нийслэлийн төсвөөр авлигын нийгмийн хор хөнөөлийг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх чиглэлээр сурталчилгааны материал, гарын авлага, 5 төрлийн сурталчилгааны материалыг хэвлүүлж, түгээсэн;

- Шударга ёсыг эрхэмлэх, төлөвшүүлэх, авлигын хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гомдол, мэдээллийг хүлээн авах утасны дугаарыг сурталчилсан радио СПОТ 6-г бэлтгэж, “Гэр бүлийн радио 104.5” радиогоор 60 удаагийн цацалт хийлгэх ажлыг зохион байгуулж, дүрсжүүлэх ажлыг Азийн сантай хамтран хийж олон нийтэд түгээсэн;
- “Тендер”, “Байцаагч”, “Эмч” сэдэвт 3 төрлийн вирал видео бэлтгэж сошиал сүлжээгээр олон нийтэд цацсан. Тухайлбал, “Тендер” сэдэвт вирал видеог 160,755, “Байцаагч” сэдэвт вирал видео 42,438, “Эмч” вирал видео 6,278 хүнд тус тус хүргэсэн. Түүнчлэн 13 яам, холбогдох агентлаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бусад эрүүл мэндийн байгууллагууд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулан сурталчлах, Олон нийтийн төвд зохион байгуулагдсан төрийн албан хаагчдад зориулсан сургалтын үеэр оролцогчдод танилцуулсан;
- Туулайхүүгийн адал явдал зохиолын баатраар зохиомжилсон хүүхэд зориулсан “Шударга хөдөлмөр илүү амттай”, “Бүгдээрээ хэрэглэдэг юмыг ганцаараа хэрэглэж болохгүй”, “Жижиг алдаанаас том гэмшил” сэдэвт 3 төрлийн 3D animation бэлтгэж цацсан. Тухайлбал, “Шударга хөдөлмөр илүү амттай” animation 18 000, “Бүгдээрээ хэрэглэдэг юмыг ганцаараа хэрэглэж болохгүй” animation 11 000, “Жижиг алдаанаас том гэмшил” animation 586 хүнд хүрсэн;
- “Өөр ирээдүй” аяны хүрээнд хийгдсэн шторк, видео болон зурагт хуудсыг НЗДТГ-тай хамтарч ажилладаг 4 телевиз болон 3 Лед дэлгэцээр 10-15 удаагийн давтамжтай цацаж олон нийтэд хүргэсэн;
- “Шударга үнэнийг дэмжинэ” гэдэг уриалгыг дэвшүүлж, үүнийхээ бэлэг тэмдэг болгон энгэртээ “нийгэмд болж бүтэхгүй байгаа муу муухай бүхнийг хавчиж гаргах ёстой” гэсэн агуулгаар бичгийн хавчаар зүүж авлигатай тэмцэж буйгаа илэрхийлэх санаачилгыг гарган ажилласан.
- “Өөр ирээдүй” аяны оддын челленжийг “Нэг үйлдэл” аянтай хамтран зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөөг батлан ажилласан. Мөн ИХЗ-ийн гишүүдийг татан оролцуулж холбогдох яам, агентлагт ажиллаж буй төрийн албан хаагч нарыг тус аянд нэгтгэж, цахим хуудас, FB профайл зургийг бичгийг хавчаараар солих ажлыг зохион байгуулан хэрэгжүүлсэн ба аянд БЗД, БГД, ЧД, СБД, Хан-Уул дүүргийн ЕБС-ийн нийт 18 сургууль, нийслэлийн 46, 59, 68, 78, 84, 87, 111 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид болох нийт 225 гаруй багш, БЗД, СБД, ЧД-ын харьяа агентлаг, байгууллагууд, Татварын ерөнхий газар, ШШГЕГ, Цагдаагийн байгууллагын нийт 120 албан хаагч тус тус нэгдсэн;
- “Олны танил” хүмүүсийг аянд нэгдүүлэхээр “Өөр Ирээдүй” Фэйсбүүк профайл солих давалгаа “Бид өөр ирээдүй хүсч байна” агуулгатай фэйсбүүк профайл фрэйм солих давалгаанд Анхаа, Рэй, Татар Мөөгий, дуучин Анхаа, Гантогоо, Жижгээ, Цогтоо, Амри /F Studio/, Дэлгэр, Шагж, Батдэлгэр нарын олны танил хүмүүс өөрсдийн цахим хуудсаа өөрчлөн уг аянд нэгдсэн;
- Авлигын эсрэг “Нэг үйлдэл” аяны хүрээнд 3 удаагийн Facebook LIVE ярилцлага явуулсан (зочноор УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү оролцсон) нь 14k удаагийн үзэлт авсан ба хэвлэл мэдээлэлд хандсан аяны уриалгыг боловсруулж 100 гаруй редакци, 200 сэтгүүлчдэд хүргүүлсний үр дүнд нь хэвлэл мэдээллийн оролцоо нэмэгдсэн;
- Хувийн хэвшлийн 5 байгууллагын бүтээлч нэг үйлдэл хийхэд дэмжлэг үзүүлсэн (Lhamour, BeautySecrets.mn, Монголын Хуульчдын Холбоо, ЦЕГ, Глоб Интернейшнл ТББ);
- Гадаадад байгаа Монголчуудыг аяны хүрээнд #НэгҮйлдэл хэрэгжүүлэхийг уриалсан-нөлөөллийн ажлын үр дүнд нийгэмд нөлөө бүхий их сургуулийн багш, хуульчид, бизнес эрхлэгчид, залуу мэргэжилтнүүдийн авлига, шударга бусын эсрэг дуу хоолой нэмэгдсэн;
- Авлигын эсрэг олон улсын өдрийг таниулсан зурагт, постер, мөн авлигын эсрэг өдрийг угтуулсан хэлэлцүүлэг, арга хэмжээнүүдийн зарыг олон нийтэд түгээж, хэвлэл мэдээлэл, иргэдийн оролцоо маш сайн хангагдсан;

• Аанхаагийн “Сайн нь муугаас олон”, “Шагж Гэлэнгийн Гарлуу биш тэмүүлэл рүү харах залуу үе”, “Хүүхдээ сургуульд оруулахдаа аргагүй байдалд орж хахууль өгсөн бол энэ тухайгаа АТГ-т мэдээлээрэй” зэрэг нийтлэлийг бэлтгэн түгээсэн нь 20000-аас дээш дагагчтай давалгаа болж өргөжсөн зэрэг болно.

Авлигын эсрэг сурталчилгааны материал, эмхэтгэл, товхимол хэвлүүлэх, түгээх ажлын хүрээнд “Тепе” ХХК-тай хамтран ажиллаж, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан тэмдэглэлийн дэвтэр А5 хэмжээтэй 1000 ширхэг (монгол хэл дээр 700 ширхэг, англи хэл дээр 300 ширхэг), карманитай хавтас 1000 ширхэг (монгол хэл дээр 700 ширхэг, англи хэл дээр 300 ширхэг), жижиг тэмдэглэлийн дэвтэр 1000 ширхэг хэвлүүлэн түгээв. Мөн Авлигатай тэмцэх газрын танилцуулгыг англи, монгол хэл дээр бэлтгэж “Интерпресс” ХХК-аар 1000, авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэлийг 3000 ширхэг (нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүжилт)-ийг хэвлүүлсэн болно.

Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдэд зориулсан эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл бэлтгэн гаргах ажлын хүрээнд тэдэнд шаардлагатай 26 хууль, дүрэм, журмын жагсаалтыг гаргаж, эхийг бэлтгэж хэвлэлтэд шилжүүлэв.

Авлигын хор хөнөөлийг иргэд олон нийтэд таниулах, шударга бус, ёс зүйгүй үйлдлийн эсрэг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Монгол контент” ХХК-аар авлига боловсролын эсрэг гэмт хэрэг, авлига хөгжил дэвшлийн эсрэг гэмт хэрэг, авлига байгаль орчны эсрэг гэмт хэрэг, авлига хүний эрхийн эсрэг гэмт хэрэг, авлига эдийн засгийн эсрэг гэмт хэрэг гэх 5 төрлийн агуулга бүхий постерын зураг зуруулж эцсийн байдлаар хүлээн авч 15.000 мянган ширхэг хэвлүүлсэн. Бэлэн болсон зурагт хуудсыг одоогийн байдлаар нийт 21 аймаг 330 суманд 5600 ширхэг, 13 яам, агентлаг дүүрэгт 3000 ширхгийг тус тус хүргүүлжээ. Түүнчлэн авлигын хор хөнөөлийг таниулах сурталчилгаа бүхий маусны тавиур, флаш, утасны дугаар тогтоогч, бал, брошур, тэмдэглэлийн дэвтэр, ханын хуанли, мэдээллийн самбар, стикер (2 төрөл), шторк зэрэг нь хэвлэлтээс гарахад бэлэн боллоо.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлын хүрээнд МҮОНТ-тэй байгуулсан гэрээний дагуу “Эрх зүйн хөтөч” 40 цуврал нэвтрүүлгийг хамтран бэлтгэж, олон нийтийн хүртээл болгосон. Түүнчлэн МҮОНР-ийн “Баримт” нэвтрүүлэгтэй хамтран авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийг ухуулах чиглэлээр 3 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн цацав.

Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад 1635 иргэнийг хамруулсан байна. Тухайлбал, Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Үндэсний аудит газар, орон нутгийн дотоод аудиторууд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ , Онцгой байдлын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Хууль сахиулахын Их сургуулийн Цагдаагийн сургууль, ЦЕГ-ын төв орон нутгийн төсөв, санхүүгийн ажилтнууд, Хууль зүйн туслалцааны төв, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай аймагт зохион байгуулсан удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон удирдах албан тушаалтан болон бусад төрийн албан хаагчдад, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дэд дарга бөгөөд ерөнхий инженер, хуулийн мэргэжилтнүүд тус тус сургалт хийлээ.

Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн шийдвэрийг хянан үзэх, хүчингүй болгох, өөрчлөх санал боловсруулж холбогдох этгээдэд хүргүүлэх арга хэмжээний хүрээнд 2017 онд яам, агентлагт ажиллах явцад илэрсэн нэн тэргүүнд хүчингүй болгуулахаар зөвлөсөн 6 шийдвэрээс тайлант хугацаанд харьяалах байгууллага, албан тушаалтан 2 шийдвэрийг өөрчилж шинэчлэн баталсан, судлах буюу төсөл боловсруулах шатанд 3, төсөлд санал авах шатанд 1 шийдвэр байна.

<u>3.3 Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, таслан зогсоох хүрээнд</u>-Тайлант хугацаанд авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн, хуулиар тусгай эрх олгоогүй байхад батлан мөрдүүлсэн, хууль тогтоомжид нийцээгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад тавих шаардлагыг хангаагүй гэж үзсэн Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалаар баталсан “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөл олгох түр журам”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох

сонгон шалгаруулалтын журам”, Эрчим хүчний сайдын 2012 оны 64 дүгээр тушаал, Эрчим хөгжлийн төвийн захирлын Б/36 дугаар тушаалаар баталсан “Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны үйлчилгээний үнэ тооцох журам”, Газрын тосны газрын даргын 2011 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2009 оны 28/01 дүгээр тэмдэглэл, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/18 дугаар тушаал зэрэг 50 гаруй дүрэм, журмыг хянан үзэж бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох арга хэмжээг авч, цахим бүртгэлд оруулах, тестлэх ажлыг гүйцэтгэв. Түүнчлэн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлан мөрдүүлсэн хууль тогтоомжид нийцээгүй, хуулиар эрх олгоогүй байхад дүрэм, журам тогтоон мөрдүүлсэн, үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон нийт 48 журмыг хянан үзэж хүчингүй болгох, өөрчлөх саналыг уламжилж, хүчингүй болгоход чиглэсэн арга хэмжээг авлаа. Тухайлбал, энэ ажлын хүрээнд Баянхонгор аймагт хамаарах 5, Говь-Алтай аймагт хамаарах 3, Завхан аймагт хамаарах 2, Өвөрхангай аймагт хамаарах 11, Өмнөговь аймагт хамаарах 3, Дундговь аймагт хамаарах 7, Увс аймагт хамаарах 4, Баян-Өлгий аймагт хамаарах 13 шийдвэрийг тус тус хянан үзсэн байна.

Тайлант хугацаанд Завхан аймгийн ЗДТГ, Багануур дүүргийн ЗДТГ, Увс аймгийн Улаангом сумын ЗДТГ, нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Ус сувгийн удирдах газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК зэрэг 9 байгууллагаас ирүүлсэн “Ёс зүйн дүрэм”-ийн төсөлтэй танилцаж, санал боловсруулан хүргүүлэв.

3.4 Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьсан талаар-Авлигатай тэмцэх газраас Засгийн газрын гишүүд болон салбарын сайд нарт 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 01/8723 дугаартай албан бичгээр хүргүүлсэн 159 асуудал бүхий “ЗӨВЛӨМЖ”-ийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг шаардах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан бөгөөд 2018.12.20-ны өдрийн байдлаар дүгнэн үзэхэд гүйцэтгэл 61.0 хувийн, 21 аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлсэн 279 асуудал бүхий “ЗӨВЛӨМЖ”-ийн хэрэгжилтийн байдалтай энэ оны 11 сард орон нутагт ажиллах явцад газар дээр нь танилцсан ба 40.0 хувийн гүйцэтгэлтэй байна гэсэн дүн гараад байна.

Тайлант хугацааны эхний хагас жилд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст хандан ирүүлсэн мөрдөгчөөс 2017 онд хүргүүлсэн 22 байгууллагын гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг бодитой арилгасан эсэхтэй танилцах, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажилласан. Хагас жилээс хойших хугацаанд 8 мэдэгдлийг хүлээн авч, мэдэгдлийн биелэлттэй газар дээр нь танилцлаа. Хэрэгжилттэй танилцах явцад мэдэгдлийг хуулийн хугацаанд ирүүлэхгүй байх, мэдэгдлийн мөрөөр авсан арга хэмжээ нь ёс төдий, зарим тохиолдолд мөрдөгчийн бичсэн мэдэгдлийг газар дээр хянан үзэж биелсэн эсэхийг дүгнэхэд хүндрэлтэй байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээний хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэл өндөр, энэ төрлийн зөрчил, гэмт хэрэг ихээр гарч байгаа салбарт урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор багийн зохион байгуулалтаар Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн үндэсний төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудад ажилласан байна. Ийнхүү ажиллах хугацаанд:

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ажиллахдаа Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Улсын байцаагчийн дүгнэлт боловсруулж гаргах тухай” шийдвэр, амьтан, ургамал, түүний эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох чиг үүрэг бүхий мэргэжлийн хяналтын байцаагч, ахлах байцаагч нарын 2017, 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, журам зэргийг судлан үзэж фокус болон ганцаарчилсан уулзалтууд хийж, эрсдэлийг бууруулах талаар холбогдох албан тушаалтнуудад чиглэл өгсөн. Мөн “АТГ-ын мэдээлэл” нэвтрүүлгээр мэргэжлийн хяналтын экспорт импортын гэрчилгээ олгох үйл ажиллагаан дахь авлигын эрсдэл, уг албан тушаалтнуудын хясан боогдуулсан үйлдлийн улмаас аргагүй байдалд орж, хээл хахууль өгсөн, түүнийгээ сайн дураараа илчилбэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх талаар тусгай

нэвтрүүлэг бэлтгэн гаргав. Үүнээс гадна мэргэжлийн хяналтын тухайн чиглэлийн байцаагчид тодорхой дүүрэг, сум хариуцан ажиллаж, хариуцсан нутаг дэвсгэрийн байгууллагууддаа шалгалт хийхэд нь удирдах албан тушаалтны зүгээс байнгын хяналт тавихад хүндрэлтэй байдаг нөхцөл байдлыг холбогдох албан тушаалтнуудад мэдэгдсэн. Мөн нийслэлийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарын сахилгын зөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт хийж, авлигын хор хөнөөлийг харуулсан *“Байцаагч”* сэдэвт видеог Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон орон нутгийн салбар байгууллагын цахим хуудсанд байршуулан сурталчлах арга хэмжээ авав.

-Автотээврийн үндэсний төвд ажиллаж, улс хоорондын ачаа тээвэрлэлт эрхлэх, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар хөтлөх, мэргэшсэн жолоочийн эрх олгох зэрэг үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрөл олгох журам, аж ахуйн нэгжүүдтэй хийсэн гэрээ болон нэмэлт өөрчлөлт, зөвшөөрөл авахад шаардлагатай бүрдүүлэх материал, мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан жолоочоос авах шалгалт, мэргэшсэн жолооны үнэмлэх хэрхэн олгож буй процесстой нэг бүрчлэн танилцаж судлан үзлээ. Тус төвд ажилласнаар авлигын эрсдэл үүсч болзошгүй ажил гүйцэтгэж байгаа ажлын байрыг тодорхойлж, цаашид Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамруулахад чиглэсэн зөвлөмжийн АТҮТ-д зөвлөсөн болно.

-Нийслэлд 2018-2019 оны хичээлийн жилийн сургуулийн өмнөх буюу төрийн өмчийн цэцэрлэгүүдийн элсэлтийг Нийслэлийн боловсролын газар 100 хувь цахимаар зохион байгуулах болсонтой холбогдуулан Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь хэсэгт заасны дагуу цахим бүртгэл болон элсэлт, элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, урьдчилан сэргийлэх шат дараалсан арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлттэй танилцах зорилгоор энэ оны 9 дүгээр сард Нийслэлийн төвийн дүүргүүдийн сургуулиуд болох 45, 1, 84, 23, 24 дүгээр сургуулиудын нэгдүгээр ангийн элсэлтийн бүртгэлийн явц байдалтай газар дээр нь танилцаж, тайлан боловсруулж, хөндөгдсөн асуудлаар хэвлэлийн мэдээ бэлтгэн олон нийтэд хүргэв. Мөн ИХЗ-ийн гишүүдийн оролцоотойгоор нийслэлийн 1, 23, 24, 11, 84, 79, 107, лабортори Шинэ эрин, Шинэ эхлэл сургууль, 2, 19, 16 дугаар цэцэрлэгийн 2018-2019 оны хичээлийн жилийн элсэлттэй холбогдуулан сургууль, цэцэрлэгийн дотоод дүрэм журам, гаргасан тушаал шийдвэр, сурагчдын хувийн хэрэг, ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн байдалтай танилцсан.

-“Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах төлөвлөгөө”-ний дагуу Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, эмнэлгийн ажилтны зан харилцаа, үйлчилгээний ачаалал, очер дугаарлалт, бүртэл, төлбөр, хураамж түүнийг авч байгаа хэлбэр зэрэгт ажиглалт, тандалт хийж, нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв; Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Шастины нэрэмжит III эмнэлэг, Улсын I төв эмнэлэгт ажилласан. Тус хэлтсээс хариуцан гүйцэтгүүлсэн *“Эмч”* сэдэвт видеог эрүүл мэндийн бүх байгууллагын цахим хуудсанд байршуулан сурталчилсан.

3.5 Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжих талаар-” Монголын залуучуудын холбоо”, “Монголын оюутны холбоо”, “Монголын Сурагчдын Холбоо” ТББ-тай байгуулсан санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эдгээр төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тусгайлсан төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд: “Монголын залуучуудын холбоо” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2018 онд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллах 5 зорилт бүхий 29 ажил, арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулсныг олон нийтэд танилцуулав. “Монголын оюутны холбоо” ТББ-тай “Хамтран ажиллах төлөвлөгөө”-г 2018 оны 7 дугаар сард баталсан ба 7 зорилтын хүрээнд 11 ажил төлөвлөснөөс 8 ажлыг тухайлбал, оюутан суралцагчдад зориулан уламжлал болгон хэвлэн гаргадаг “Оюутны хөтөч-2018” номонд авлига түүнээс ангид байх, түүний хор хөнөөлийн тухай мэдээллийг нийтлүүлэх, “Монголын оюутны холбоо”-ны вэб хуудас болон нүүр номонд авлига, түүнээс ангид байх сурталчилгааны мэдээллийг байршуулах, “Миний

мэргэжил эх орны минь хөгжлийн гарц” сэдэвт мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын мэдээллийг боловсруулах, “Авлига түүнээс ангид хүн” шударга ёсны төлөвшилт лекцийг их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн 396 оюутан залуусын дунд, мөн “Шударга ёс зүйтэй найзаа алдаршуулъя” уриалга гаргаж, фэйсбүүк хуудсаар аян зохион байгуулах зэрэг ажлыг хамтран зохион байгуулав.

Шударга ёсыг эрхэмлэх, төлөвшүүлэх, авлигын хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор радиогийн богино хэмжээний нэвтрүүлэг СПОТ бэлтгэж, дүрсжүүлэн олон нийтийн хүртээл болгосон, мөн “Өөр ирээдүй хүсч байна” аяныг “Вишн” ХХК-тай хамтран зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн Туулайхүүгийн 3D анимэйшн 3, шторк видео 3, нийтлэл 2-ыг болон аяны уриа, логог АТГ-ын facebook хуудас, Хамтдаа.мн сошиал хуудаст, хэвлэл мэдээллийн байгууллагууд (ТВ25, Ийгл ТВ, UBS телевиз, төрийн байгууллагуудын цахим хуудас, 2 сошиал хуудсаар)-аар түгээсэн. Мөн аяныг танилцуулах зорилгоор “Монголын залуучуудын холбоо”, “Монголын Оюутын холбоо” ТББ-тай хамтран хэвлэлийн бага хурал хийж, иргэдэд мэдээлэл хүргэх чиглэлээр ажиллалаа.

Энэхүү аяны хүрээнд 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс хойш хугацаанд Facebook хуудсаар 259340 хандалт, 3 видео шторк нийт 209471, 2 нийтлэл 30401, аяны зураг лого 12611 (давхардсан тоогоор) хүн хүрсэн байна.

Түүнчлэн бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай сургалтын хөтөлбөр шинэчлэх, шүгэл үлээгч, түүнийг хамгаалах зэрэг сэдвээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, танилцуулга хийх, мэдээлэл өгөх, санал солилцох чиглэлээр хамтран ажиллав. Тухайлбал, Азийн сан, Хууль сахиулахын их сургуультай хамтран ёс зүйн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх асуудлаар санал солилцох уулзалтад оролцож, сургалтын хөтөлбөр агуулгыг шинэчлэх чиглэлээр, ангар.мн цахим хуудсанд шүгэл үлээгчийг хамгаалах асуудлаар, Транспэренси интернешнл ТББ-аас зохион байгуулсан улс төрийн намын санхүүжилтийн эрх зүйн орчныг ил тод болгох чиглэлээр, “Иргэний боловсрол төв” ТББ-аас зохион байгуулсан “Иргэн” төслийн танилцуулга, шалгаруулалтын үйл ажиллагаатай танилцаж, хамтран ажиллах талаар, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ болон Азийн сан хамтран зохион байгуулсан “Хариуцлага оюутан залуус” төслийн хүрээнд “Дээд боловсрол: ёс зүй, ил тод, шударга байдал” уулзалт хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл солилцох чиглэлээр, Lead Mongolia хөтөлбөрийн манлайлагч залуустай хамтран “Гэрэл тусгая” арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр тус тус хамтран ажиллалаа.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны хүрээнд мэдүүлэг мэдүүлэх хуулийн хугацаа сануулсан сурталчилгааны баннерыг “Өнөөдөр” сонин, “news.mn” сайтуудад, мөн “Хууль сануулсан сурталчилгаа”-ны видеог “ТВ-8”, “ТВ-5”, “ТВ-25”, “MYOHTB”, “ТВ-9”, “UBS”, “Монгол HD” “Парламент суваг” телевиз гэх мэт 8 телевизэд байршуулсан.

Дөрөв. Судалгаа, дүн шинжилгээний ажлын чиглэлээр

4.1 Судалгааны ажлын талаар-Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 болон 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу зохион байгуулж байсан Авлигын индексийн судалгаа болон Төрийн байгууллагын шударга байдлын судалгааг нэгтгэн Шударга байдлын үнэлгээний судалгаа болгон зохион байгуулж байгаа бөгөөд Шударга байдлын үнэлгээ 2018 оны судалгааг гэрээний үндсэн дээр хийлгэж, судалгааны тайланг хүлээн авч, дүнг танилцуулах, мэдээлэх ажлыг зохион байгуулав.

Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолын дагуу зохион байгуулдаг Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн 2017 оны судалгааны үр дүнгийн тооцооллыг хийж, тайланг бэлтгэв.

Улс, төрийн байгууллагын хүрээн дэх авлигын төсөөлөл, Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөлөл 2 төрлийн судалгааг Максима консалтинг компаниар хийлгүүлэхээр гэрээ байгуулав. Судалгааны явц байдлын талаар Максима консалтинг компанитай тогтмол холбоотой байж зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллав. Тус компаниас Улс, төрийн байгууллагын хүрээн дэх авлигын төсөөлөл, Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөлөл хоёр судалгааны тайлан, асуулга, фокус бүлгийн ярилцлага зэрэг бүх материалыг гэрээнд заасан хугацаанд хүлээн авсан.

Хүүхдийн шударга байдал-2017 судалгааг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулав. Судалгааны мэдээллийг 21 аймаг, 9 дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 7-12 дугаар ангийн сурагчдыг хамруулан 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хугацаанд зохион байгуулав. “Хүүхдийн шударга байдал”-ын 2017 оны судалгааны үр дүнгийн тооцооллыг хийж тайланг боловсруулан байгууллагын цахим сайтад байршуулав.

“Сурагчдын холбоо” төрийн бус байгууллагын ажилтнуудад хүүхдийн шударга байдлын судалгааны талаар мэдээлэл өгч, хичээл бэлтгүүлэн Дорнод, Өмнөговь, Орхон, Орхон зэрэг аймгуудын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, эцэг эхчүүдэд танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр олон нийтэд судалгааны үр дүнг түгээх ажлыг зохион байгууллаа.

Хүүхдийн шударга байдлын 2018 оны судалгааг зохион байгуулах, үр дүнг тооцож, тайланг боловсруулах ажлыг “Сурагчдын холбоо” төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр гэрээ хийв. “Сурагчдын холбоо” ТББ-ын ажилтнуудад судалгааны түүвэр, арга зүй, асуулгыг танилцуулан, судалгааны мэдээлэл цуглуулах линкийг холбогдох албан тушаалтанд мэйлээр хүргүүлэн мэдээлэл цуглуулах ажлыг эхлүүлж, заавар, зөвлөгөө өгч ажиллав. Судалгааны үр дүнг тооцох, тайлан боловсруулсан.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарч байгаа авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээ, мэдээлэл, нийтлэлд судалгааг “Хэвлэлийн хүрээлэн” төрийн бус байгууллага, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын төсөөлөл” судалгааг “Хэрэглээний боловсрол, судлалын хүрээлэн” төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, тайланг хүлээн авсан болно.

4.2 Дүн шинжилгээний ажлын талаар-Байгууллагад 2017 онд хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэл болон нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн шийдвэрлэлтийн 2015-2017 оны мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Мөн Ашигт малтмалын лицензийг эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжийн, Хүнс, хөдөө, аж ахуйн яамны тэжээлийн тендерийн зээлд хамрагдсан 29 байгууллага, аж ахуйн нэгжийн, эрчим хүчний салбарт тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуй нэгжийн, “Оюу Толгой” ХХК-д 2008-2012 онд бараа үйлчилгээ нийлүүлж байсан 413 аж ахуй нэгжийн, тус компанид 2017 онд бараа үйлчилгээ нийлүүлж байсан аж ахуй нэгж, иргэний мэдээлэл, Оюу Толгой” ХХК-ийн 2010-2017 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүд, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, иргэний мэдээлэл болон хэвлэлд нийтлэгдсэн өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээг хүчингүй болгосон талаарх, “Олимпиад нэрийн дор сурагчдаар бизнес хийж байна”, шүлхий өвчний тархалтын талаарх, “Тэг рупи”-ийн авлига буюу 5 дахь зарчим, Энэтхэг дэх авлигын эсрэг иргэний нийгмийн хөдөлгөөний талаарх, Эрдэнэт үйлдвэрийн орлогч захирал асан Д.Даваасамбуутай холбоотой иргэний нийгмийн хөдөлгөөний талаарх, “Жаст групп”-тэй холбоотой гарсан мэдээллүүд, Жаст групптэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл, Оюу толгой ХХК-ийн ТУЗ-ийн 2010-2017 оны шийдвэрүүд, цагдаагийн байгууллагын албан хаагчдад холбогдох гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, авто зам барих, засварлах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэлд тус тус дүн шинжилгээ хийв.

“Транспаренси Интернэшл” байгууллагаас 2017 оны “Авлигын төсөөллийн индекс”-ийг зарласантай холбоотой мэдээллийн танилцуулга, Монгол Улсын “Авлигын төсөөллийн индекс” буурсан шалтгаан нөхцөлийн талаарх танилцуулга, “Стамбулын Авлигын эсрэг төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Монгол Улс хэрхэн хангаж буй талаарх явцын тайланг тус тус бэлтгэв.

“Шударга ёс” сэтгүүлийн 2017 оны сүүлийн хагас жилийн дугаарыг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулав. 2018 оны дугаарыг бэлтгэн хэвлэлтэд шилжүүлээд байна.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан “Авлигатай тэмцэх гарын авлага”-ын хэвлэлийн эхийг эцэслэн боловсруулж, хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгосон.

Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу 24 яам,

агентлагт авлигын эрсдэлийн үнэлгээ хийх, тайлан боловсруулах, зөвлөмж хүргүүлэх төрийн бус байгууллага болон судалгааны байгууллагатай тогтмол харилцан, ажлын даалгавар, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгч ажиллав. Тус ажлын хүрээнд гэрээт ажил гүйцэтгэсэн 6 ТББ-аас 24 байгууллагын тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийж товч тайланг бэлтгэн үр дүнг яам, агентлагт танилцуулах ажлыг зохион байгуулав.

2019 онд эрсдэлийн үнэлгээг 15 байгууллагад хийлгэхээр судалгааны чиглэлийн төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулав.

Тав. Хяналт шалгалт, дүн шинжилгээний
ажлын чиглэлээр:

5.1 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар-Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Төрийн захиргааны болон нутгийн захиргааны нийт 106 байгууллагаас хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг /цаашид “ХАСХОМ” гэх/-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, нэгдсэн дүн, мэдээг гаргасан.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2018 оны 02 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт 40073 мэдүүлэг гаргагч /цахим хэлбэрээр-36409, хэвлэмэл байдлаар-3664/ мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 40067 мэдүүлэг гаргагч мэдүүлж, 4 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулж, 2 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй буюу гаргахаас татгалзсан дүнтэй байна.


Хүснэгт 1: ХАСХОМ гаргасан албан тушаалтнуудын тоон үзүүлэлт

Үзүүлэлт		2016	2017
Бүрдүүлбэл зохих		39742	40073
Бүрдүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн тоо		39739	40067
Үүнээс:	Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	1	4
	Мэдүүлгээ гаргаж өгөөгүй	2	2
Бүрдүүлэлтийн хувь		99.99	99.99

Хуулийн хугацаанд мэдүүлгээ гаргаж бүртгүүлээгүй, зөрчил гаргасан дээрх албан тушаалтнуудад хуулийн дагуу хариуцлага тооцуулах, цаашид хуулийн хугацаанд мэдүүлгийг бүрэн гүйцэд гаргуулах, өөрийн харьяа салбар нэгж байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн нийтлэг үүргийг хэрэгжүүлэн, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар шаардлага хүргүүлсэн.


2017 оны ХАСХОМ-ээ шинэчлэн гаргасан нийт мэдүүлэг гаргагчдыг ангиллаар нь авч үзвэл 13478 буюу 33.6 хувь нь төрийн тусгай, 10440 буюу 26.1 хувь нь төрийн захиргааны, 7443 буюу 18.6 хувь нь улс төрийн, 4370 буюу 10.9 хувь нь төрийн үйлчилгээний удирдах, 272 буюу 0.7 хувь нь төрийн өндөр болон АТГ-т мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтан, 4070 буюу 10.1 хувь нь бусад албан тушаалтан байна.

Хүснэгт 2: ХАСХОМ гаргасан албан тушаалтан



Нийт мэдүүлэг гаргагчийн 21885 буюу 54.6 хувь нь Улаанбаатар хотод, 18188 буюу 45.4 хувь нь орон нутагт, 6011 буюу 39.9 хувийг ахлах мэргэжилтэн, түүнээс дээш ангиллын албан тушаалтнууд эзэлж байна.

Хүснэгт 3: ХАСХОМ мэдүүлсэн мэдүүлэг гаргагчийн тоо /аймгаар/



Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээний дүнгээс үзэхэд 850 мэдүүлэг гаргагч “хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлж, 32287 мэдүүлэг гаргагч “тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл, 850 мэдүүлэг гаргагч “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан дүнтэй байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10^1 дүгээр зүйлийн 10^1.3-т Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 326 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллав. Оффшор бүсэд нээлгэсэн банкны дансаа хаалгах, банкинд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээг авсан талаар мэдүүлэх хуулийн хугацаа 2018 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд уг хугацаанд хуульд заасан үүргээ биелүүлж, оффшор бүс дэх хөрөнгөө шилжүүлсэн болон уг бүсэд хамаарах нутаг дэвсгэрт эд хөрөнгө, данс эзэмшиж байгаа талаараа нийт 20 албан тушаалтан Авлигатай тэмцэх газарт мэдүүлсэн. Үүнд:

Улсын Их Хурлын 2 гишүүн, Монголбанкны 1 албан тушаалтан өөрийн хамаарал бүхий этгээдийн эзэмшиж байсан оффшор бүсэд бүртгэлтэй компанийн хувьцааг 2015, 2017 онд бусдад шилжүүлсэн, Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагын удирдах 1 албан тушаалтан өөрийн эзэмшиж байсан гурван дансыг хаалгасан тухай мэдүүлж бүртгүүлсэн.

Түүнчлэн оффшор бүсэд хамаарах гадаад улсад албаны чиг үүргээ хэрэгжүүлэх, суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор банкинд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө өмчилсөн 16 албан тушаалтан энэ тухай Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдсэн.

Дээрх мэдээллийг тус газрын цахим сайтад байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав.

Төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжоор хангах зорилгоор Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан албан тушаал эрхэлж байгаа нийт 236 албан тушаалтны 2017 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг http://www.xacxom.iaac.mn нээлттэй сайтад байршуулсан.

5.2 Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өндөр болон бусад албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар-Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-т заасан чиг үүргийн дагуу Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ

бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр 282 албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэж байгаа 272 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд шинэчлэн гаргаж бүртгүүлэхээс 271 албан тушаалтан мэдүүлсэн. Дээрх албан тушаалтнуудын жагсаалтыг гаргаж, мэдүүлэг гаргагчдад зөвлөмж, чиглэл өгч арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тагнуулын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, АНУ-ын Вашингтон, Япон улсын Токио, Канад Улсын Оттава дахь Элчин сайд, Эрчим хүчний зохицуулах хорооны орон тооны бус зохицуулагч, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон тооны бус гишүүн буюу нийт 10 албан тушаалд томилгоо хийгдээгүй байсан болно. Мөн Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасан үндэслэлийн дагуу төрийн өндөр албан тушаалтан болон Үндсэн хуулийн цэц, Шүүхийн ерөнхий зөвлөлд ХОМ-ээ мэдүүлсэн холбогдох албан тушаалтнуудын ХОМ-ийг татан авч, хяналт тавьж ажилласан бөгөөд тэдгээрийн ХОМ-ийг хураангуй хэлбэрээр тус газрын цахим мэдээллийн сүлжээнд байршуулах бэлтгэл ажлыг ханган ажилласан.

Тайлант хугацаанд шинээр томилогдсон 12 /БСШУС-ын дэд сайд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, ЗГ-ын ХЭГ-ын дэд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга, Үндсэн хуулийн цэцийн 4 гишүүн, Зам тээврийн яамны дэд сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын дарга, Оюуны өмчийн газрын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Эрчим хүчний зохицуулах хорооны орон тооны бус гишүүн зэрэг/ албан тушаалтны эрхийг нь цахим системд нээж, ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргуулах талаар зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан. Мөн төрийн өндөр 9 албан тушаалтан /УИХ-ын гишүүн-2, ЗГ-ын гишүүн сайд-1, Төрийн нарийн бичгийн дарга-1, агентлагийн дарга-3, бусад/ их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлснийг хуулийн хугацаанд гаргуулж авсан болно.

5.3 Сургалт сурталчилгаа, мэдээлэл арга зүйн ажлын талаар-Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны хүрээнд сургалт сурталчилгааг зохих журмын дагуу хийж, хуулийн хугацаа сануулсан сурталчилгааны баннерыг “Өнөөдөр” сонин, “news.mn” сайтуудад, мөн “Хууль сануулсан сурталчилгаа”-ны видеог “ТВ-8”, “ТВ-5”, “ТВ-25”, “МҮОНТВ”, “ТВ-9”, “UBS”, “Монгол HD” “Парламент суваг” телевиз гэх мэт 8 телевизүүдэд байршуулж, холбогдох гэрээг байгуулан биелэлтийг хангаж ажилласан.

Мөн мэдүүлэг гаргагчид болон байгууллага, салбар нэгжийн эрх бүхий албан тушаалтнуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, заавар зөвлөмж, өгч ажиллахаас гадна ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн явц байдал, хуулийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх хүрээнд тус газрын хэвлэлийн ажилтнаар дамжуулан тухай бүр дэлгэрэнгүй мэдээллийг өгч, хэвлэл мэдээллийн хэрэгслээр, мэдээлэл, ярилцлага өгч олон нийтийг мэдээллээр ханган ажилласан байна.

2018 онд “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан гарын авлага” номын шинэчилсэн 7 дахь, “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”-ыг 5 дахь удаагаа шинэчлэн боловсруулж, хэвлүүлэн төрийн байгууллага, мэдүүлэг гаргагч, ЭБАТ нарыг гарын авлагаар хангасан.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны хүрээнд Говьсүмбэр, Дорноговь, Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Завхан, Хэнтий, Өвөрхангай, Говь-Алтай аймаг болон Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Сэлэнгэ аймгийн Хөтөл сум, мөн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, Шинжлэх ухааны академи, Татварын ерөнхий газар, нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ, УБЕГ зэрэг 32 байгууллагын нийт 3446 мэдүүлэг гаргагчдыг, нийт 302 эрх бүхий албан тушаалтныг нэгдсэн сургалтад хамруулж, арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа.

Хүснэгт 4: Сургалтад хамрагдагсдын тоон үзүүлэлт



Мөн Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.16-д заасан чиг үүргийн хүрээнд хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж, тодруулга авахаар албан бичгээр хүсэлт ирүүлсэн байгууллага, албан тушаалтан, мэдүүлэг гаргагч нарт тухай бүрт нь утсаар, албан бичгээр зөвлөмж, чиглэл өгч ажилласан бөгөөд оффшор бүсэд хамаарах хориглолтын талаар яам, агентлаг, аймаг, нийслэл болон холбогдох албан тушаалтнуудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл өгч, хуулийг сурталчлан таниулах ажиллагааг зохион байгуулав.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 21-ний өдөр баталсан хуваарийн дагуу 2018 оны 3-5 дугаар саруудад Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа нийт 17 байгууллагын 10154, Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага болох аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, аймаг, Нийслэлийн ЗДТГ-ын харьяа агентлагийн нийт 15440, Улсын Их Хурлын харьяа байгууллага болох Монгол банк, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газар, Сонгуулийн ерөнхий хороо, Авлигатай тэмцэх газар болон Сангийн яам, Зам тээврийн хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам зэрэг нийт 43 байгууллагын 9991 орчим мэдүүлэг гаргагч буюу нийт 36409 мэдүүлэг гаргагчдын 2017 оны ХОМ-ийн хураангуйг тус газрын http://www.xacxom.iaac.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажилласан.

Дүн шинжилгээний ажлын талаар-Цахим системд 2017 оны ХАСХОМ-ээ гаргаж бүртгүүлсэн нийт 36409 мэдүүлэг гаргагчдаас мэдүүлгийн төрөл бүрээр нь хамгийн өндөр, үзүүлэлттэй, өндөр тоо ширхэгтэй, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлого хөрөнгийг хамгийн их үнийн дүнгээр илэрхийлсэн эхний 10 мэдүүлэг гаргагчдыг үзүүлэлт тус бүрээр нь сүүлийн 2 жилийн орлого, хөрөнгийн төрлөөр нь харьцуулан судалж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулсан.

Мөн шүүгчдийн ХАСХОМ-д дээрх төрөл бүрээр судалгаа, харьцуулалт хийж, хамгийн өндөр үнийн дүнтэй болон өндөр үнэлгээтэй орлого, хөрөнгийн байдалд үнэлгээ дүгнэлт өгч, хөрөнгө, орлого нь жилээс жилд өссөн, нарийвчлан хянан шалгах шаардлага бүхий шүүгчдийн ХАСХОМ-ийн талаарх судалгаа, мэдээллийг нэгтгэн боловсруулсан.

Нийтийн албаны тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн талаар иргэн, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол мэдээллийн 2013-2017 онуудын байдалд харьцуулалт, судалгаа хийж гомдлын агуулга, гомдолд холбогдон шалгагдсан албан тушаалтан, салбараар нь харьцуулан судалж, цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний саналыг боловсруулав.

2018 онд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч 40073 албан тушаалтны албан тушаал, албан тушаалын ангилал зэрэглэл, суурьшлын байдлаар нь болон аймаг тус бүрээр нь дүн шинжилгээ хийв.

Мөн гадаад улсад үл хөдлөх хөрөнгөтэй, хадгаламжтай гэж мэдүүлсэн албан тушаалтнуудын талаарх судалгаа, мэдээллийг гаргаж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглахаас гадна Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлэв.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн болон мэдүүлгийн цахим систем ашиглан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ болон хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/ гаргаж байгаа мэдүүлэг гаргагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын нэгдсэн жагсаалт, тоон үзүүлэлтийг гарган дүн шинжилгээ хийсэн. Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст 2013-2017 онд хянан шалгагдаж шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдол мэдээлэлд харьцуулалт, судалгаа хийж, мэдээллийг нэгтгэн боловсруулсан.

Төрийн албан тушаалтны томилгооны талаарх судалгааг 2016-2017, 2017-2018 оны байдлаар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасныг үндэслэн улс төрийн нөлөө бүхий гэх нийт 299 албан тушаалтны судалгааг тус тус гаргав.

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ээ гаргаж бүртгүүлсэн албан хаагч нараас бүх шатны шүүхийн шүүгчид, Үндсэн хуулийн цэцийн гишүүд болох нийт 519 шүүгчийн 2016, 2017 оны ХАСХОМ-ийн байдалд хяналт тавьж мэдүүлгийн төрөл бүрээр нь харьцуулалт, судалгааг хийж гаргасан. Үүнд: 100 сая төгрөг буюу түүнээс дээш орлоготой гэж мэдүүлсэн мэдүүлэг гаргагчийн өөрийн орлого, гэр бүлийн гишүүдийн орлого, 4 буюу түүнээс дээш тооны орон сууц, барилга байгууламж, 500 сая төгрөг буюу түүнээс дээш үнэ бүхий орон сууц, барилга байгууламж, 2 буюу түүнээс дээш тооны, 100 сая дээш төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл, 100 сая буюу түүнээс дээш төгрөгийн үнэлгээ бүхий мал аж ахуй, газар, үнэт эдлэл, хадгаламж, авлага, зээл болон компани, хуулийн этгээдийн тоо, хөрөнгө оруулсан дүрмийн сан болон бусад гэсэн үзүүлэлтээр судалгааг хийгээд байна.

5.5 Бүрдүүлэлтийн хяналт шалгалт, хариуцлага тооцуулсан талаар-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийн явц байдлыг хянан шалгах үйл ажиллагааны хүрээнд тус газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд хэлтсийн нийт ажилтнууд өөрсдийн хариуцсан салбарын яам, агентлаг, нийслэл, дүүрэг, төрийн өмчит ХХК-иудад Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилт болон бүрдүүлэлтийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажилласан.

Шалгалтаар өөрийн болон хамаарал бүхий этгээдтэйгээ холбоотой тушаал, шийдвэр гаргахдаа мэдэгдэл гаргаагүй, ХАСХОМ-ээ хуулийн хугацаанд гаргаж бүртгүүлээгүй, хугацаа хожимдуулж мэдүүлсэн, ХАСУМ хянуулаагүй томилогдсон зэрэг нийт 199 зөрчлийг илрүүлсэн. Ашигт малтмал, газрын тосны газар, “Эрдэнэс Монгол” ХХК, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, СБД-ийн ЗДТГ, нийслэлийн Газрын алба, нийслэлийн Боловсролын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг газруудын нийт 68 албан тушаалтанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцох албан бичгийг хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан байна.


Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, арга зүйн туслалцаа үзүүлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр 2018 оны 10. 11 дүгээр сард 21 аймаг, 30 гаруй суманд ажиллаж, ХАСХОМ-ээ хуулийн хугацаанд гаргаагүй, хугацаа хожимдуулсан болон ХАСУМ хянуулалгүй томилсон нийт 264 зөрчлийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авав.

Тайлант хугацаанд Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн хууль бус нийт 463 зөрчлийг илрүүлсэн бөгөөд зарим зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, зөрчил гаргасан зарим албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан гэх мэт нөхцөл байдал илэрсэн хэдий ч хууль, тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй, зөрчил гаргасан нийт 197 албан тушаалтанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

хуульд заасны дагуу 124 албан тушаалтанд сануулах, 67 албан тушаалтанд албан тушаалын цалингийн хэмжээг бууруулах, 6 албан тушаалтныг нийтийн албанаас халах сахилгын арга хэмжээ тооцуулсан байна.

5.6 Хяналт шалгалтын талаар-2018 онд шинээр хүлээн авсан 216, өмнөх оны үлдэгдэл 34, нийт 250 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгахаар хүлээн авснаас 171 мэдүүлгийг шалгаж, 79 албан тушаалтны мэдүүлгийг одоогоор шалгаж байна. Тайлант хугацаанд 72 буюу 33.3 хувийг гомдол, мэдээллийн мөрөөр, 79 буюу 36.6 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 65 буюу 30.1 хувийг Мөрдөн шалгах хэлтсийн хүсэлтээр шалгасан байна.

Хүснэгт 5: Мэдүүлгийн хяналт шалгалтын үзүүлэлт
/өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдлаар/:



Тайлангийн хугацаанд ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар нийт 14 албан тушаалтанд хуульд заасан хариуцлага тооцуулсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 29 нэгжээр буюу 67.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХАСХОМ-ийн харьцуулсан судалгаа:

	Өмнөх оны үлдэгдэл ХАСХОМ	Тайлант хугацаанд хүлээж авсан ХАСХОМ	Шалгавал зохих нийт ХАСХОМ	Шалгаж шийдвэрлэсэн ХАСХОМ	Үлдэгдэл ХАСХОМ	Хариуцлага тооцуулсан байдал
2017	32	276	308	274	34	43
2018	34	216	250	171	79	14

ХАСХОМ шалгахдаа зөвхөн тухайн албан тушаалтны өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгийн байдлыг шалгахаар хязгаарлалгүйгээр тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдийн эд хөрөнгө, орлогын эх үүсвэрийг нягтлах замаар нуугдмал эд хөрөнгийг илрүүлэхэд анхаарч ажиллаж байна. Тухайлбал, 2017 онд нийт 274 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгаж, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болзошгүй үндэслэлээр 5 албан тушаалтан буюу 1.8 хувийг нь МШХ-т шилжүүлж байсан бол 2018 онд нийт 171 ХАСХОМ хянан шийдвэрлэсний 20 албан тушаалтан буюу 8 хувийг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн байж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлж МШХ, ГАХ-т шилжүүлсэн байна.

5.7 Өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар-2018 онд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 629, /өмнөх оны үлдэгдэл 43/ нийт 672 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас тайлант хугацаанд 622 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд одоо 50 өргөдөл, гомдол, мэдээлэл ажиллагаанд хянагдаж байна.

Хүлээн авсан өргөдөл, гомдлыг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 73 буюу 11 хувиар, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол нь 66 буюу 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүлээж авсан нийт өргөдөл, гомдлын 284 буюу 47.0 хувийг Улаанбаатар хотоос, 315 буюу 52.6 хувийг хөдөө, орон нутгаас ирүүлсэн байна. Баян-Өлгий аймаг 5.3 хувь, Архангай

аймаг 3.3 хувь, Төв аймаг 3.2 хувь, Хөвсгөл аймаг 3.0 хувийг эзэлж байгаа нь бусад аймгаас өндөр үзүүлэлт болж байна. Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлын талаар нийт гомдол гаргагч нарт хариуг хүргүүлсэн бөгөөд 62 хувьд нь албан бичгээр, 38.0 хувьд нь амаар, утсаар, цахим сүлжээгээр мэдэгдсэн байна.


Шалган шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийн агуулгыг үзвэл:

- Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн талаар 94 буюу 15.1 хувийг,
- Албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон бусдад давуу байдал олгосон талаар 89 буюу 14.3 хувийг,
- Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил гаргаж, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн талаар 63 буюу 10.1 хувийг,
- Ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр, хууль бус үйлдэл гаргасан талаар 148 буюу 23.8 хувийг,
- Албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгуулах талаар 27 буюу 4.3 хувийг,
- Хүнд суртал, ёс зүйн зөрчил шалгуулах талаар 39 буюу 6.3 хувийг
-Худалдан авах ажиллагаа болон тендер сонгон шалгаруулалтын талаар шалгуулах 31 буюу 5.0 хувийг,
- Бусад 131 буюу 21.1 хувийг тус тус эзэлж байна.

Өргөдөл, гомдлын мөрөөр хяналт шалгалтыг хэрэгжүүлж, зөрчил гаргасан 38 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулан, хуулийн хэрэгжилтийг хангуулж, 8 зөрчлийг арилгуулж, тухайн зөрчил үүсэх эсхүл олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх нөхцөлийг үүсгэж байгаа талаар тухай бүр анхааруулж ажиллав.

Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэс болон Гүйцэтгэх ажлын хэлтэст 95 гомдол, мэдээллийг шилжүүлсэн байна.

Хүснэгт 7: Өргөдөл, гомдол мэдээлэл шийдвэрлэсэн байдал



5.8 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан ажлын талаар- 2018 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 10436, өмнөх оны үлдэгдэл 28 нийт 10464 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас 10381 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, одоо 83 мэдүүлэг хянагдаж байна.

Тайлант хугацаанд ирүүлсэн ХАСУМ-ийн 8619 буюу 82.6 хувийг Улаанбаатар хотоос, 1817 буюу 17.4 хувийг хөдөө, орон нутгаас ирүүлсэн. Орон нутгаас ирүүлсэн ХАСУМ-ийг аймгаар авч үзвэл: Завхан аймаг 149, Өмнөговь аймгаас 136, Дорноговь аймгаас 112 нэр дэвшигчийг хянуулахаар ирүүлсэн нь өндөр дүнтэй байна.

Хянан шалгасан урьдчилсан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан нийт 844, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр 439 мэдүүлгийг буцаан хүргүүлж, 25 нэр дэвшигч тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад мэдэгдсэн.
Хүснэгт 8: Хянан шалгасан урьдчилсан мэдүүлэг

	Нийт хүлээн авсан ХАСУМ	Хянан шийдвэрлэсэн ХАСУМ	АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоог доогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон	Хууль, журамд заасан үндэслэлээр буцаасан	Нарийвчлан шалгах шаардлагатай	Үлдэгдэл
			Үүнээс:					
2017	11143	11115	9329	763	39	968	14	28
2018	10464	10381	9063	844	25	439	10	83

2018 оны тоон үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан мэдүүлэг 679 нэгжээр, хянан шалгаж хариу өгсөн мэдүүлэг 734 нэгжээр тус тус буурсан байна.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар албан тушаалд томилогдсон өдрөөс хойш мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй 197, ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн 14, ХАСУМ-ийн хяналт шалгалтаар давхар ажил эрхлэхтэй холбоотой хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн 2, ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн /хяналт шалгалтаар тогтоогдсон/ 38, нийт 251 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна.

Хүснэгт 9: Хариуцлага тооцуулсан байдал /шалгалтын төрлөөр/


№	Хариуцлагын төрөл	Шалгалтын төрлөөр				Хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо
		Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар	ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар	Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар	ХАСУМ-ийн хяналт шалгалтаар	
1	Сануулсан	124	3	8	-	135
2	Цалинг бууруулсан	67	10	23	2	102
3	Албан тушаал бууруулсан	-	-	-	-	-
4	Ажлаас халсан	6	1	7	-	14
Дүн		197	14	38	2	251

Зургаа: Мөрдөн шалгах ажлын талаар

6.1 Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн талаар-2018 онд гэмт хэргийн шинжтэй 858 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 200 нэгжээр буюу их буюу 23.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн шинжтэй 858 гомдол мэдээллээс 447 гомдол, мэдээлэл буюу 52.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх санал гаргасан, 327 гомдол, мэдээлэл буюу 38.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргасан, 76 гомдол, мэдээлэл буюу 8.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж, 8 гомдлын үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 98.9 хувьтай байна.

Гэмт хэргийн шинжтэй 858 гомдол мэдээллээс 447 гомдол, мэдээлэл буюу 52.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх санал гаргасан, 327 гомдол, мэдээлэл буюу 38.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргасан, 76 гомдол, мэдээлэл буюу 8.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлж, 8 гомдлын үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 98.9 хувьтай байна.



Гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалтнаар нь ангилбал, төрийн улс төрийн 127, төрийн захиргааны 232, төрийн тусгай 248, төрийн үйлчилгээний 149, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн 41, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах 61 албан тушаалтан холбогдон шалгагдсан байна.

Мөрдөн шалгах хэлтэст хүлээн авч шалгасан 858 гомдлын 501 буюу 58.4 хувийг Улаанбаатар, 357 буюу 41.6 хувийг орон нутгийн харьяаллын гомдол эзэлж байна.

6.2 Эрүүгийн хэргийн талаар-2018 оны байдлаар 1473 үйлдэлтэй, 1224 холбогдогчтой 1138 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсныг 2017 онд 654 холбогдогчтой, 427 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан мөн үетэй харьцуулбал, 711 нэгжээр буюу 2.7 дахин өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд эрүүгийн 9 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцдаа нийт 25 үйлдлийг шинээр илрүүлсэн.


Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг төрлөөр нь ангилбал:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-461 буюу 31.3 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Хахууль авах/-140 буюу 9.5 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/-142 буюу буюу 9.6 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/-40 буюу 2.7 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.9 дугаар зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/-6 буюу 0.4 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/-25 буюу 1.7 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/-17 буюу 1.1 хувь,
- Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйл /Хөрөнгө завших/-51 буюу 3.6 хувь
- Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/ 42 буюу 2.9 хувь
- болон бусад хэрэг 545 буюу 37.0 хувийг тус тус эзэлж байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн 224 буюу шалгасан хэргийн 19.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтайгаар прокурорт, 467 буюу шалгасан хэргийн 41.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтайгаар прокурорт, 125 буюу шалгасан хэргийн 10.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 9 хэрэг буюу 0.8 хувийг бусад эрүүгийн хэрэгт нэгтгэж, 1 хэргийг түдгэлзүүлж, одоо 312 эрүүгийн хэргийн үлдэгдэл /27.4 хувь/-тэй байна.


Эдгээр үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөрдөн шалгасан хэрэг 224-2.7 дахин, шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 2.1 дахин, харьяаллын дагуу шилжүүлсэн хэрэг 2.6 дахин, хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 4.9 дахин, үлдэгдэл хэрэг 1.9 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байх ба мөрдөн шалгасан хэргийн 72.5 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн дүнтэй байна.





Эрүүгийн хэрэгт 1224 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна. Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 434 буюу 35.4 хувийг төрийн тусгай, 204 буюу 16.7 хувийг төрийн захиргааны, 193 буюу 15.8 хувийг иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн албан тушаалтан, 82 буюу 6.7 хувийг төрийн өмчит болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн албан тушаалтан, 166 буюу 13.6 хувийг төрийн улс төрийн, 145 буюу 11.8 хувийг төрийн үйлчилгээний албан тушаалтан эзэлж байна.

2018 онд гэмт хэргийн улмаас 663,213,994,905 төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 17,470,753,533 төгрөгийг нөхөн төлүүлж үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 180,650,089,526 төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 10 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 5 дахин, хохирол нөхөн төлүүлэлд 6 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Мөн хугацаан дахь мөрдөгч нарын ажлын ачааллыг дунджаар авч үзвэл 1 мөрдөгч 30.6 /2017 онд 24.6 байсан/ гомдол, мэдээлэл шалгаж, 40.6 /15.9 байсан/ эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гомдол, мэдээлэл 6, эрүүгийн хэрэг 24.7 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Тайлант хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нийт 85 үйлдлийг шинээр илрүүлсэн байна.

6.3 Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн талаар-2017 онд шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн 106 хэргээс 46 /43.3/ эрүүгийн хэрэг шийдвэрлэж байсан бол 2018 онд нийт 224 хэрэг шүүхээр шийдвэрлүүлэхээр прокурорт шилжүүлснээс 84 /37.5 хувь/ хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн дүнтэй байна. Үүнд: Автотээврийн үндэсний төвийн тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Д.Б, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны санхүүгийн газрын даргаар ажиллаж байсан Д.Б, Барилга хот байгуулалтын сайдаар ажиллаж байсан Ц.Б, Гаалийн Ерөнхий газрын Төрийн захиргаа, хамтын ажиллагааны газрын даргаар ажиллаж байсан Б.О, НӨХГ-ын Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Б, ахлах мэргэжилтэн Э.Э, Төрийн орон сууц санхүүжилтийн корпорацын хуулийн хэлтсийн дарга Б.Б, Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Засаг дарга А.М, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлт хариуцсан байцаагч Б.З, Баянгол дүүргийн татварын байцаагч А.Э, Хан-Уул дүүргийн татварын байцаагч Н.П, Батлан хамгаалах яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын орлогч дарга, хурандаа Ж.А, ДЦС-4 төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал С.А зэрэг төрийн албан тушаалтнуудад холбогдох хэргийг шүүхээр шийдвэрлүүлээд байна.

---oOo---